

ЭХЭМҮТ-ИЙН ЧИХ ХАМАР ХООЛОЙН МЭС ЗАСЛЫН ТАСАГ

Анх 1956 онд Хүүхдийн Чих хамар хоолойн анхны кабинетэд Зөвлөлтийн эмч И.Колесникова, сувилагч Т.Цэвэгжав нар ажиллаж эхэлсэнээр Хүүхдийн ЧХХ-н алба анх байгуулагдсан байдаг. 1957 онд Ё.Намжилмаа Чих хамар хоолойн кабинетад ажиллаж эхлэн үндэсний анхны ЧХХ-н мэргэжлийн эмч болсон байна.

Одоо ЧХХМЗТ-нь ХЗП-т ЧХХ-н 2 кабинет, сонгол судлал, сонсгол засал, хэл заслын кабинеттай нийт 11 эмч, 7 сувилагч, 1 лаборанттай үйл ажиллагаагаа явуулж байна.


ЧХХМЗТ нь ОРЧИН ҮЕИЙН ЭМЧИЛГЭЭ ОНОШИЛГООНЫ ЧИГ ХАНДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ЦАГ ТУХАЙД НЬ АВЧ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ ЭН ТЭРГҮҮНД ТАВЬЖ, БАГАЖ ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ ХИЙХ үндсэн асуудлыг цогцоор нь шийдэж ажиллах, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ шуурхай бөгөөд үр дүнтэй, эмчилгээ оношилгоо оновчтой хийх, эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүй, харьцаа хандлагийг дээдлэн ажиллаж байна.

ЧХХМЗТ нь БНСУ-ын Самсунгийн эмнэлэг, Сөүлийн УИС-ийн ЧХХ-н тасаг, Тайванийн Үндэсний Их Сургуулийн Чих, хамар, хоолойн тасагтай болон Дэлхийн Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн дэлхийн сан, Солонгос улсын Рафаэль сан ОУ-н Ротари клубтэй хамтран ажилладаг.

Тус тасагт хийгдэж байгаа шинэ дэвшилтэт мэс заслууд :

- Сонсголын ясыг протезоор орлуулах чихний нөхөн сэргээх мэс засал
- Дунгийн суулгацын анхны мэс засал
- Хамар, чихний дурангийн мэс засал
- Төрөлхийн гадна чихний дэлбэн, суваггүй сонсголгүй хүүхдэд суваг гаргах мэс засал
- Төрөлхийн гадна чихний дэлбэн, суваггүй сонсголгүй хүүхдэд сонсгол оруулах ВАНА аппарат суулгах
- Дунгийн суулгацын дараах тохиргоо
- Залгиур, төвөнх, бронхийн уян дурангийн оношлогоо
- Сонсголын цогц шинжилгээнүүд
- Төвөнх, мөгөөрсөн хоолойг хэлбэн тэлэх эмчилгээ
- Дунгийн суулгацын дараах сонсгол, хэл засал
- Бага насны (3-6) хүүхдэд сонсголыг харж батжуулах болон зан төлөвийн аудиометрийн аргаар шалгах кабинетийг Монгол улсын хэмжээнд анх удаа шинээр ашиглалтанд оруулж зориулалтын төхөөрөмжийг суурилуулсан.

- Сонсгол, хэл яриа заслыг битүүмжлэгдсэн зориулалтын өрөөнд гүйцэтгэх боломж бүрдсэн Аутизм өвчнийг оношлох зан байдлын шалгах хуудас (The ASD Assessment Scale/ Screening Questionnaire) ашиглаж эхэлсэн.
- Ангиографийн тусламжтайгаар тэжээгч судсыг судсан дотор бөглөж, хамрын хөндийн судаслаг хавдрыг (Ангифиброма) дурангаар авах мэс засал
- Төрөлхийн 2 чихний суваг битүү хүүхдэд сонсголын ясан дамжуулагчийг суулгах мэс заслыг БНСУ-ийн эмч мэргэжилтэнгүүдтэй хамтран Монголд анх удаа хийж шинэ технологийг эхлүүлсэн.
- Оу-д хүүхдийн чихний гаралтай хавдрыг ЧХХ-н тасагт эмчлэгддэг дэлхийн жишгийг нэвтрүүлж чадсан.
- Бамбай булчирхайн биопсийн шинжилгээ бүрэн нутагшуулсан.



Хүний нөөцийн бүрэлдхүүн

- Анагаах Ухааны доктор,дэд профессор-1
- Зөвлөх зэргийн эмч Клиникийн профессор -1
- Тэргүүлэх зэргийн эмч-3
- Ахлах зэргийн эмч-1
- АШУ-ны магистр эмч-2
- Анагаах ухааны доктрант– 1
- Сувилахуйн бакалавр сувилагч – 3
- Ахлах зэрэгтэй сувилагч –2

Тасгийн зөвлөх эмч



ЭРДЭНЭЧУЛУУН овогтой ЖАРГАЛХҮҮ

**Монгол улсын ХҮНИЙ ГАВЪЯАТ ЭМЧ,
Анагаах ухааны доктор, Дэд профессор,
Монгол улсын ЗӨВЛӨХ зэргийн эмч**
ЭМЯ-ны ЧХХ судлалын салбар зөвлөлийн ерөнхий
мэргэжилтэн

Мэргэжил:

2001 онд ЭМШУҮИС Хүний их эмч

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2003 онд ЭМШУИС “Чих хамар хоолой судлал”
- 2003-2025 онуудад ХБНГУ-ийн Вюрцбургийн Их Сургуулийн клиникт “Чих хамар хоолой”, “Мэс засал”, “ДААД”, “Чих хамар хоолойн мэс засал”
- 2007-2025 онуудад БНСУ-ын үндэсний их сургуулийн Бунданг, Бура эмнэлэгт “Чих хамар хоолойн мэс засал”
- 2009-2019 онуудад Австрали улс, Хонконг улс, БНХАУ-ын Бээжингийн их сургуульд “Чих хамар хоолойн мэс засал” “Дунд, дотор чихний мэс засал”
- 2012 онд БНСУ-ын HANA-ENT чих хамар хоолойн эмнэлэгт “Хамрын дурангийн мэс засал”
- 2014, 2015, 2016 онуудад БНСУ-ын Чусон их сургуулийн эмнэлэгт “Чих хамар хоолойн мэс засал” БНСУ-ын Доктор Чин эмнэлэгт “Хамрын гоо сайхны мэс засал”

Тасгийн эрхлэгч



БАТААХҮҮ овогтой ДЭГЭРМАА

МУ-ийн хүний гавьяат эмч
АУ-ны магистр
Клиникийн профессор
Зөвлөх зэргийн эмч

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 1985-1987 АУДyC
- 1987-1993 АУДэC-ийн хүүхдийн эмч мэргэжлээр
- 1995 онд Чих хамар хоолойн мэргэжил олгох курс
- 1997 онд Анагаах ухааны магистр
- 2002 онд ЧХХ-н ахлах зэрэг
- 2008 онд ЧХХ-н тэргүүлэх зэрэг
- 2012 онд клиникийн профессор
- 2020 онд ЧХХ-н зөвлөх зэрэг

Ажлын туршлага:

- 1993.07-1994.04 сард СБД-ийн хүүхдийн 2-р эмнэлгийн сэхээн амьдруулах тасагт их эмч
- 1994 .04-2013.11 сард ЭНЭШТ-ийн Чих хамар хоолойн тасагт хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын эмч
- 2013 оноос ЭХЭМҮТ-ийн Чих хамар хоолойн тасгийн эрхлэгчээр одоог хүртэл
- Хүүхдийн чихний бичил мэс засал, хамар, залгиур, төвөнхийн дурангийн мэс заслаар мэргэшсэн



Лхамсүрэн овогтой Раднаацэрэн

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2007 онд ЭМШУИС хүний их эмч
- 2011 онд Чих хамар хоолойн эмч
- 2018 онд Чих хамар хоолойн ахлах зэргийн эмч
- 2021 онд эмнэлзүйн сургагч багшийн сургалт

Ажлын туршлага:

- 2007-2010 БЗД-ийн эмнэлэгт хүний их эмчээр
- 2011 оноос оноос ЭХЭМҮТ-д ЧХХМЗТасагт чих хамар хоолойн эмчээр одоог хүртэл.
- Хүүхдийн чихний бичил мэс засал, сонсгол оруулах дунгийн суулгац, хамар, залгиурын дурангийн мэс заслаар мэргэшсэн



Баярмагнай овогтой Батболд

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

2010 онд ЭМШУИС-ийн МДИ-ийг ЧХХ танхимыг Чих Хамар Хоолойн эмчээр төгссөн

2019 онд Чих хамар хоолойн ахлах зэргийн эмч

2021 онд Хүүхдийн чих хамар хоолой судлал

2021 онд эмнэлзүйн сургагч багшийн сургалт

Ажлын туршлага:

- 2011-14 онд Ионсайн-Найрамдал эмнэлэгт ЧХХ эмчээр
- 2015-17 онд Төгс-Сонсголон эмнэлэгт ЧХХ эмчээр
- 2017 оноос ЭХЭМҮТ-д ЧХХМЗТасагт чих хамар хоолойн эмчээр одоог хүртэл.
- Хамрын пластик мэс засал, хамар, залгиурын дурангийн мэс засал, төрөлхийн төвөнх-мөгөөрсөн хоолойн пластик мэс заслаар мэргэшсэн

Чулуунбаатар овогтой Саруул



Мэргэжил дээшлүүлсэн байдал:

2001-2007 Москва хотын Улс Түмний Найрамдлын Их Сургууль, АУИС- -Хүний их эмч

2009-2011 Москва хотын Улс Түмний Найрамдлын Их Сургууль, АУИС- Чих хамар хоолойн ординатура, магистрантура

2020 онд Чих хамар хоолойн ахлах зэргийн эмч

2021 онд Хүүхдийн чих хамар хоолой судлал

2022 онд эмнэлзүйн сургагч багшийн сургалт

Ажлын туршлага:

- 2011-2012 он АШУҮИС-дадлагажигч багш
- 2012 оноос ЭХЭМҮТ- ЧХХМЗТ-чих хамар хоолой, сонгсолын эмчээр одоог хүртэл ажиллаж байна.
- Хүүхдийн сонсгол судлал, дунгийн суулгацын дараах сонсголын тохируулгаар мэргэшсэн



Эрдэнэчулуун овогтой Энхнаран

Мэргэжил дээшлүүлсэн байдал

- 2007-2013 ЭМШУИС-ийг Хүний их эмч
- 2016-2018 Чих Хамар Хоолойн эмчээр төгссөн
- 2020-2021 Хүүхдийн чих хамар хоолой судлал
- 2021-2022 Толгой хүзүүний мэс засал

Ажлын туршлага:

- 2013-2016 БЗД 6-р хороо өрхийн эрүүл мэндийн төвд хүний их эмч
- 2020- 2021-АШУҮИС - АУ-ны Магистр
- 2019-с оноос ЭХЭМҮТ-д ЧХХМЗТасагт чих хамар хоолойн эмчээр одоог хүртэл.
- Толгой хүзүүний мэс засал, дуу авиа судлал, хамар залгиурын дурангийн мэс заслаар мэргэшсэн



Батболд овогтой Энхсайхан

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2011-2017 АШУҮИС-Хүний их эмч
- 2017-2019 АШУҮИС - Чих хамар хоолойн мэс заслын эмч
- 2018-2020 АШУҮИС - АУ-ны Магистр
- 2020 онд - Хүүхдийн чих хамар хоолой судлал

Ажлын туршлага:

- 2019 оноос ЭХЭМҮТ- ЧХХМЗТ-их эмчээр ажиллаж байна.
- Хамар, залгиурын мэс заслаар мэргэшсэн



Энхжаргал овогтой Ундрах

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2010-2016 АШУҮИС-Хүний их эмч
- 2018-2020 АШУҮИС - Чих хамар хоолойн мэс заслын эмч
- 2022 онд - Хүүхдийн чих хамар хоолой судлал

Ажлын туршлага:

- 2016-2018 онд Булган аймаг, Нэгдсэн эмнэлэгт ЯТТ – их эмчээр
- 2020 оноос- ЭХЭМҮТ- ЧХХМЗТ-их эмчээр
- Хамар, чих, залгиурын дурангийн мэс заслаар мэргэшсэн



Сайханбаяр овогтой Одончимэг

Сонсгол заслын эмч

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2012-2018 АШУҮИС Хүний их эмч
- 2018-2021 АШУҮИС Чих хамар хоолойн эмч
- 2023 он АШУҮИС Чих хамар хоолойн мэс засал
- 2025 он Сонсгол засал, хэл засал

Ажлын туршлага :

- 2021- 2024 онд АШУҮИС-ийн Төв эмнэлэгт Чих хамар хоолойн эмч
- 2023-2024 онд АШУҮИС-ийн ЧХХ тэнхимд гэрээт багш
- 2024 оны 09 сараас 2025 оны 01 сар ЭХЭМҮТ-ийн ХЗП Чих хамар хоолойн эмч
- 2025 оны 01 сараас ЭХЭМҮТ-ийн ХЗП Сонсгол заслын эмч



Нямхүү овогтой Мягмарзул

Хэл засал, Хүүхдийн мэдрэлийн эмч

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2007-2014 ЭМШУИС Хүний их эмч
- 2015-2017 АШУҮИС Хүүхдийн эмч
- 2022 он АШУҮИС хүүхдийн мэдрэл судлал
- 2022 он ОХУ Улан-Үд Боловсролын бодлогын хүрээлэн Хэл засалч
- 2025 он АШУҮИС Хүүхэд өсвөр үеийн сэтгэц судлал
- 2025 он Хүүхэд хөгжилийн үнэлгээний мэргэжилтэн“ Монгол Танака бине ”

Ажлын туршлага:

- 2014-2015 он БЗД 17 хорооны ӨЭМТ-ийн их эмч
- 2017-2018 он Сүхбаатар НЭ-т хүүхдийн эмч
- 2020-2022 он НЕБ-ийн 55 сургууль эмч, хэл засалч
- 2022-2024 он НХСЗ “Бяцхан тэмүүлэл төв” Мэдрэл хэл заслын эмч
- 2025 оны 1 сараас ЭХЭМҮТ ХЗП-ийн Хэл заслын эмч



Мөнхбат овогтой Алтанзаяа

Чих хамар хоолойн эмч

Мэргэжил Дээшлүүлсэн Байдал :

- 2011-2017 он АЧ АУИС хүний их эмч
- 2021-2023 он Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгийн Чих хамар хоолойн тасагт Резидент эмч

Ажлын туршлага:

- 2018-2021 он Нийслэлийн Түргэн Тусламжын Төв их эмч
- 2024 он Эх хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төв Хүүхдийн чих хамар хоолойн олгох эмч
- 2025 он ЭХЭМҮТ-н Чих Хамар Хоолойн Тасагт Чих хамар хоолойн эмчээр өдийг хүртэл ажиллаж байна



Пүрэвдорж овогтой Итгэл

Чих хамар хоолойн эмч

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2014-2020 АШУҮИС Хүний их эмч
- 2021-2023 АШУҮИС-МДИ- Чих хамар хоолойн резидент эмч
- 2023-2024 Эрүүл мэндийн хөгжлийн төв Хүүхдийн чих хамар хоолойн төрөлжсөн мэргэжлийн олгох курс
- 2023-2025 Эмнэлзүйн анагаах ухааны магистрант

Ажлын туршлага:

- 2025 оноос ЭХЭМҮТ-ХЗП-Чих хамар хоолойн эмч



Сувилахуйн арга зүйч

Батсуурь овогтой Оюунгэрэл

Мэрэгжил дээшлүүлсэн байдал :

- 2007-2011 АУ-ны “Энэрэл” дээд сургууль
- 2014 онд ЭМШУИС- ийн Чих хамар хоолойн мэргэшлийн сувилагч
- 2023 онд Ахлах зэрэг

Ажлын туршлага:

- 2011оны 07 сараас 2024 оны 12сар хүртэл ЭХЭМҮТ- ийн Чих хамар хоолойн тасгийн сувилагч
- 2024оны 12 сарын 05-аас ЭХЭМҮТ- ийн Чих хамар хоолойн тасгийн Ахлах сувилагчаар одоог хүртэл ажиллаж



Хорлоо овогтой Оюунтуяа

Мэрэгжил дээшлүүлсэн байдал:

- 1999онд мэс засал курс
- 1999 онд сэргээн засах курс
- 2011 онд АШУҮИС –ийн сувилахуйн баклавар
- 2021 Ахлах зэрэг

Ажлын туршлага:

- 1984 онд Эрдэнэт хотын цэргийн эмнэлэгт сувилагчаар ажилласан.
- 1985-1987 онд Булган аймаг сувилагчаар ажилласан.
- 1995-2025 оны одоог хүртэл ажиллаж байна.




Дарамбазар овогтой Загдсүрэн

Мэрэгжил дээшлүүлсэн байдал:

- 1989- 1991 онд Сувилагчийн Дунд Сургуульд элсэн суралцаж төгссөн.
- 1995 онд Чих хамар хоолойн хагалгааны сувилагчийн курс төгссөн.
- 2003-2005 онд ЭМШУИС-ийн сувилахуйн бакалаврын ангид элсэн суралцаж төгссөн.
- 2004 онд Сонсгол судлалын лаборантын 3 сарын олгох курс төгссөн.
- 2005 онд Сувилагчийн “ Ахлах ” зэрэг хамгаалсан.
- 2020 онд Сувилагчийн “ Тэргүүлэх” зэрэг ажилттай хамгаалсан.

Ажлын туршлага :

- ЭНЭШТөвийн Чих хамар хоолойн тасагт хагалгааны асрагчаар орж ажилласан.
- 2007-2024 он хүртэл чих хамар хоолойн мэс заслын тасгийн ахлах сувилагчаар тус тус ажиллаж байна.
- 2025 оноос одоог хүртэл үзлэг, боолтын сувилагчаар ажиллаж байна.



Мядагбал овогтой Ганцэцэг

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2007 онд Улаанбаатар хотын сувилагчийн дунд сургуулийг сувилагч мэргэжлээр
 - 2007 онд ЭМШУИС МДИ сэргээн засах курс
 - 2014 онд ЭМШУИС МДИ Чих хамар хоолойн сувилагч
 - 2018 онд Ахлах зэрэг

Ажлын туршлага :

- 1990 онд ЭНЭШТөвийн ариутгалын тасагт асрагчаар ажилсан.
- 1991 онд Улаанбаатар хотын сувлагчийн дунд сургуулийг сувилагч мэргэжлээр төгссөн.
- 1993 онд ЭНЭШТ нярайн эрчимт эмчилгээний тасагт сувилагчаар орсон.
- 1994 оноос сонсгол судлалын тасагт сувилагчаар ажилласан.
- 2006 оноос Чих хамар хоолойн тасагт одоог хүртэл ажиллаж байна.



Цэрэндаш овогтой Дудиарий

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2009 онд ЭМШИУС-ийн сувилахуйн сургуулийг төгссөн
- 2014 онд ЭМШУИС МДИ Чих хамар хоолойн сувилагчийн олгох 3 сарын курс төгссөн.

Ажлын туршлага :

- 1997-2006 он хүртэл ЭХЭМҮТ-ийн Чих хамар хоолойн мэс заслын тасагт хагалгааны асрагч
- 2006 онд ЭМШУИС-ийн харъяа сувилахуйн сургуулийг сувилагч мэргэжлээр
- 2009 оноос одоог хүртэл чих хамар хоолойн мэс заслын тасагт тасралтгүй ажиллаж байна.
- 2021 онд Ахлах зэрэг



Эрдэнэжаргал овогтой Гэрэлмаа

Мэргэжил дээшлүүлсэн байдал:

- 2008 онд ЭМШУИС-ийн сувилахуйн сургууль сувилагч мэргэжлээр
 - 2020 онд Хүүхдийн мэргэжил дээшлүүлэх курс
 - 2020 онд Ахлах зэрэг

Ажлын туршлага:

- 2008 оноос одоог хүртэл чих хамар хоолойн мэс заслын тасагт тасралтгүй ажиллаж байна.